8	Бага сургууль	13,947.0	14,255.3	308.3	4.66
	Салбарын нийт дүн	276,258.9	305,870.3	29,611.4	100.00

Эх сурвалж: Баянлиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 324001.6 мянган төгрөгийн бараа материалын 297564.6 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 19660.7 төгрөгийн материал хандиваар, 3451.4 мянган төгрөгийн материал шилжүүлэн авсан, 3325.0 мянган төгрөгийн материал дотоод шилжүүлэг болоод бусад хэлбэрээр авсан байна.

Хандиваар авсан 19660.7 мянган төгрөгийн материалын Засаг даргын Тамгын газар 680.0 мянга, Ерөнхий боловсролын сургууль 630.0, Эрүүл мэндийн төв 17928.3 мянга, цэцэрлэг 291.4 мянган төгрөгийн Ковид-19 цар тахалтай холбоотой халдвар, хамгаалал, эм эмнэлгийн хэрэгсэл иргэн аж ахуйн нэгжээс хандиваар нийлүүлснийг бүртгэсэн байна.

Мөн бусад хэсэгт бүртгэсэн 3325.0 мянган төгрөгийн бараа материал нь сумын цэцэрлэгийн тооллогоор илэрсэн бүртгэгдээгүй зөөлөн эдлэлийг энэ ангилалд оруулсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	324,001.6	Хасагдсан	294,390.2
Худалдан авсан	297,564.6	Худалдсан, зарцуулсан	276,583.2
Хандиваар	19,660.7	Шилжүүлсэн	33.0
Шилжүүлэн авсан	3,451.4	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	0.0
Бусад	3,325.0	Бусад	17,774.0

Эх сурвалж: Баянлиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 16013695.4 мянга, эцсийн үлдэгдэл 16150994.3 мянган төгрөг болж, 137298.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	15,863,806.2	15,980,803.3	116,997.1	98.9
Барилга байгууламж, орон сууц	14,002,656.8	14,018,152.3	15,495.5	86.8
Тээврийн хэсэгсэл	372,750.2	325,740.8	(47,009.4)	2.0
Машин тоног төхөөрөмж	764,330.6	865,505.6	101,175.0	5.4
Тавилга эд хогшил	431,480.9	473,256.7	41,775.8	2.9
Дуусаагүй барилга	13,612.3	13,612.3	-	0.1
Түүх соёлын дурсгалт зүйл			-	-
Номын фонд	35,980.7	41,540.9	5,560.2	0.3
Бусад үндсэн хөрөнгө	242,994.7	242,994.7	-	1.5
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	149,889.2	170,191.0	20,301.8	1.05
Програм хангамж	3,654.0	3,634.0	(20.0)	0.0
Бусад биет бус хөрөнгө	146,235.2	166,557.0	20,321.8	1.0
Дүн	16,013,695.4	16,150,994.3	137,298.9	100.00

Эх сурвалж: Баянлиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 186901.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь урсгал төсвийн худалдан авалтаар 68118.7 мянга, хандиваар ирсэн нийт хөрөнгө болох 70567.5 мянган төгрөгийн хөрөнгө нь Засаг даргын тамгын газарт Дэлхийн зөн олон улсын байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлсэн 12495.5 мянган төгрөгийн өвсний фондны барилга, ОНХС-ийн хөрөнгөөр баригдсан 3000,0 мянган төгрөгийн өртөг бүхий гүний худгийг ашиглалтад оруулсан байна. Мөн Дэлхийн зөн олон улсын байгууллагаас соёлын төвд 646.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Ерөнхий боловсролын сургуульд 12050.0 мянган төгрөгийн сандал, ширээ зэргийг нийлүүлсэн байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

№	Байгууллагуудын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	39,111.8	21,679.6	(17,432.2)	0.1
2	Засаг даргын Тамгын газар	4,912,001.4	4,947,096.5	35,095.1	30.6
3	Сургууль	5,501,529.4	5,574,708.0	73,178.6	34.5
4	Цэцэрлэг	1,346,150.6	1,360,258.0	14,107.4	8.4
5	Эрүүл мэндийн төв	2,029,711.5	2,043,039.2	13,327.7	12.6
6	Соёлын төв	2,024,475.3	2,032,087.3	7,612.0	12.6
7	Бага сургууль	160,715.4	173,918.8	13,203.4	1.1
	Салбарын нийт дүн	16,013,695.4	16,152,787.4	139,092.0	100.0

Эх сурвалж: Баянлиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 32433.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан ба аймгийн Эрүүл мэндийн газраас сумын Эрүүл мэндийн төвд 4675.4 мянган төгрөгийн халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийг шилжүүлснийг бүртгэсэн байна.

Мөн үндсэн хөрөнгийн бусад ангиллын 15782.3 мянган төгрөгийн хөрөнгө нь сумын Ерөнхий боловсролын сургуульд БСШУЯ-аас ирүүлсэн 2469.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас ирүүлсэн 10462.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, сумын Соёлын төвийн 2400.0 төгрөгийн өртөг бүхий газрыг энэ ангилалд бүртгэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	186,901.4	Хасагдсан	47,809.4
Худалдан авсан	68,118.7	Худалдсан	0.0
Хандиваар	70,567.5	Акталсан	47,809.4
Шилжүүлэн авсан	32,433.0	Шилжүүлсэн	0.0
Бусад	15,782.3	Бусад	0.0

Эх сурвалж: Баянлиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 33.4 мянга, эцсийн үлдэгдэл 3614.0 мянган төгрөг болж 3580.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	33.4	3,614.0	3,580.6	100.0
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	33.4	30.2	(3.2)	0.8
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,151.8	3,151.8	87.2
41361	Байгууллагад төлөх өглөг	-	432.0	432.0	12.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-	-
	Дүн	33.4	3,614.0	3,580.6	100.0

Эх сурвалж: Баянлиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 3580.6 мянган төгрөгийн өглөг нь ажиллагсадтай холбоотой 30.2 мянга, бараа үйлчилгээний зардлын өглөг 3151.8 мянга, байгууллагад өгөх өглөг 432.0 мянган төгрөгийн өглөг байна. Үүнээс сумын Эрүүл мэндийн төвийн байгууллагад өгөх өглөг буюу 3151.8 мянган төгрөг нь 2020 оны жилийн эцсийн гүйлгээ хаагдсанаас хойш санхүүжилт орж ирснээр эмийн өглөг үүссэн байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Д.д	Байгууллагуудын нэр	Өглөгийн эхний үлдэгдэл	Өглөгийн эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
1	Сургууль	3.2	-	(3.2)	-
2	Цэцэрлэг	-	432.0	432.0	12.1
3	Эрүүл мэндийн төв	-	3,151.8	3,151.8	87.9
	ТШЗ-ийн байгууллагын ДҮН	3.2	3,583.8	3,580.6	100.0

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 14485260.9 мянга, эцсийн үлдэгдэл 13994595.1 мянган төгрөг болж, 688193.4 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Хувийн жин
51	Засгийн газрын хувь оролцоо	14,485,260.9	13,994,595.2	(490,665.70)	100.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,686,124.8	1,688,524.8	2,400.0	12.1
51101	Өмч: - төрийн	1,686,124.8	1,688,524.8	2,400.0	12.1
512	Хуримтлагдсан үр дүн	11,713,878.6	11,220,812.7	(493,065.9)	80.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,085,257.6	1,085,257.6	-	7.8
	Дүн	14,485,261.0	13,994,595.1	(490,665.9)	100.0

Эх сурвалж: Баянлиг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 14485260,9 мянган төгрөг болж 13994595.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 493665.9 мянган төгрөгийн бууралттай холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.18-ны өдрийн 12/04 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 90820.0 мянга, хүү торгуулийн орлогыг 2500.0 мянга, нийт 93320.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.09.25-ны өдрийн 13/02 дугаар тогтоолоор сумын төсөвт

төвлөрүүлэх орлогыг нийт 1000.0 мянган төгрөгөөр нэмэж тодотгон татварын орлогыг 91820.0 мянга, хүү торгуулийн орлогыг 2500.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Дд	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сумд төвлөрөх орлогын дүн		91,820.0	123,772.0	31,952.0	134.8
1	ИОТХ	16,000.0	43,410.1	27,410.1	271.3
2	хадгаламжийн хүүгийн орлого	61,000.0	62,427.9	1,427.9	102.3
3	ҮХЭХ борлуулсны албан татвар	-	1,641.9	1,641.9	-
4	Бууны татвар	1,400.0	1,410.0	10.0	100.7
5	Улсын тэмдэгт	2,500.0	2,180.5	(319.5)	87.2
6	Газрын төлбөр	1,920.0	1,085.8	(834.2)	56.6
7	Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	9,000.0	11,615.8	2,615.8	129.1
8	ТТАМАТөлбөр	-	-	-	-
9	Нохойны татвар	-	-	-	-
Татварын бус орлого		2,500.0	5,281.5	2,781.5	211.3
10	Хүү торгууль	2,500.0	5,281.5	2,781.5	211.3
Дүн		94,320.0	129,053.5	34,733.5	136.8

Сумын төсөвт төвлөрөх улсын тэмдэгтийн хураамж, газрын төлөвлөгөөнөөс бусад татварын орлогыг 34733.5 мянган төгрөгөөр буюу 36.8 хувиар давуулан биелүүлсэн байна. ИОТХ-ын орлого нь давсан шалтгаан нь 2020 оны 12 дугаар сард “Эрдэнэс таван толгой” ХК-ны ногдол ашгийн орлогын суутган татвараас шалтгаалсан байна.

Сумын ИТХ-ын 2020.09.25-ны өдрийн хуралдаанаар 13/02 дугаар тогтоолоор сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлогыг нийт 1000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр Засаг даргын Тамгын газар 4200.0 мянган төгрөгийн орлого оруулсныг тайланд бүртгэжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 35983.2 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 49901.9 мянган төгрөгийн орлогыг оруулсан бол ОНХС-д өвс тэжээл, малжуулахын эргэн төлөлтийн орлогоор 34978.0 мянган төгрөг орсныг орлогоор бүртгэж тайлагнасан байна

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 3423579.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3036853.6 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2828217.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 180653,5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны төсөв батлах тухай 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолд зааснаар Баянлиг сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 7800.0 мянга, аймгийн төсөвт 114900.0 мянга, нийт 122700.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 125586.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №14. Улс, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А. Улсын төсөв	7800.0	7587.3	-212.7	97.3
1. ААНБ-н орлогын татвар	1500.0	3505.2	2005.2	233.7
2. НӨАТатвар	5000.0	2127.5	-2872.5	42.6
4. Агаарын бохирдол/авто/	1300.0	1954.6	654.6	150.4
В. Аймгийн төсөв /712/	114900.0	117999.2	3099.2	102.7
1. ЦХТА орлого /Суутган-1/	147000.0	180093.2	33093.2	122.5
2. АТӨЯХ-н татвар	18000.0	21994.3	3994.3	122.2
3. ҮХЭХ-ийн татвар	3000.0	3132.0	132.0	104.4
4. Газрын төлбөр	2880.0	1532.0	-1348.0	53.2
Дун	122700.0	125586.5	2886.5	102.4

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 6 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019.12.18-ны өдрийн 12/04 дугаар тогтоолоор нийт 3474368.0 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	ТТөсөл	Анх батлагдсан	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	85,416.0	88,096.7	2,680.7
Засаг даргын Тамгын газар	596,696.9	457,952.3	(138,744.6)
Сургууль	889,246.9	994,731.0	105,484.1
Цэцэрлэг	342,281.1	347,340.0	5,058.9
Эрүүл мэндийн төв			-
Соёлын төв	190,874.0	78,726.8	(112,147.2)
Бага сургууль	152,047.1	150,833.4	(1,213.7)
Сум хөгжүүлэх сан		180,000.0	180,000.0
Орон нутгийн хөгжлийн сан		287,356.2	287,356.2
Дун	2,256,562.0	2,585,036.4	328,474.4

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.18-ны өдрийн 13/01 дугаар тогтоолоор анх баталсан 3031415.1 мянган төгрөгийг 2020.09.25-ны өдрийн 15/01 дугаар тогтоолоор 21066.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.10.27-ны өдрийн А/701 дугаар захирамжаар 35733.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 88734.5 мянган төгрөгөөр бууруулж, 2020.12.31-ний өдрийн А/771 дугаар захирамжаар 0.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2999481.1 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1667140.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 40790.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 107356.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 823193.5 мянган төгрөгийг аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 97567.2 мянга, 141000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 122432.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 6584.4 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 41480.8 мянган төгрөг дутуу, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 3833.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Баянлиг сумын ЗДТГ	380,617.4	371,608.6	9,008.8	97.6
2	Баянлиг сумын ИТХ	68,078.9	67,360.2	718.7	98.9
3	Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль	1,400,407.7	1,284,658.2	115,749.5	91.7
4	Баянлиг сумын бага сургууль	133,026.3	111,203.3	21,823.0	83.6
5	Баянлиг сумын Цэцэрлэг	392,445.1	368,788.6	23,656.5	94.0
6	Баянлиг сумын Хүн эмнэлэг	544,574.9	540,667.7	3,907.2	99.3
7	Баянлиг сумын Соёлын төв	111,601.4	111,357.1	244.3	99.8
8	Баянлиг сумын ОНХС	298,885.0	180,653.5	118,231.5	60.4
9	Баянлиг сумын СХС	102,943.2	556.4	102,386.8	0.5
	Дүн	3,432,579.9	3,036,853.6	395,726.3	88.5

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3036853.6 мянган төгрөг буюу 88.5 хувьтай байгаа нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын урсгал зардлыг 718.7 мянга, Засаг даргын Тамгын урсгал зардлыг 9008.8 мянга, цэцэрлэгийн урсгал зардлыг 23656.5 мянга, ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 115749.5 мянга, бага сургуулийн урсгал зардлыг 21823.0 мянга, Хүн эмнэлгийн урсгал зардлыг 3907.2 мянга, Соёлын төвийн урсгал зардлыг 244.3 мянган төгрөг төгрөгөөр тус тус хэмнэж сум хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг 102386.8 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг 118231.5 мянган төгрөгөөр дутуу олгосон нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 16. Баянлиг сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөөлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хуви
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,423,579.90	3,036,853.60	0.39	88.70
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	68,078.90	67,360.18	0.72	98.94
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	55,867.60	55,148.88	0.72	98.71
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	-	-	-	
80825 Багийн ИНХ-ын дарны урамшуулал	12,211.30	12,211.30	-	100.00
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	380,617.40	371,608.64	9.01	97.63
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	284,083.00	282,126.45	1.96	99.31
80106 Баг, хорооны ҮАЗардал	66,007.40	63,183.45	2.82	95.72
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	4,739.10	4,739.10	-	100.00
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	15,239.70	15,239.54	0.00	100.00
82212 Хур хог хаягдал, орчны бохирдл	10,548.20	6,320.10	4.23	59.92
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	289,885.00	180,653.50	109.23	62.32
80904 Нийгмийн зориулалттай барилга	289,885.00	180,653.50	109.23	62.32
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	544,574.90	540,667.67	3.91	99.28
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	71,324.70	70,825.81	0.50	99.30
80302 Нэг иргэнд ногдох нормативаар	24,257.70	24,257.43	0.00	100.00
81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлч	448,992.50	445,584.43	3.41	99.24
71702 Соёл урлаг	111,601.40	111,357.08	0.24	99.78
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	108,151.40	107,907.08	0.24	99.77
80214 Уран бүтээл хийлгэх	2,000.00	2,000.00	-	100.00
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,450.00	1,450.00	-	100.00
71801 Сургуулийн өмнөх боловсрол	392,445.10	368,788.64	23.66	93.97
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	38,916.90	36,167.76	2.75	92.94
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	195.90	195.30	0.00	99.69
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	27,081.60	22,134.84	4.95	81.73
81831 Ээлжийн бүлэгт хамруулах	15,930.20	12,944.46	2.99	81.26
81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	7,804.50	7,804.47	0.00	100.00
81833 Явуулын бапшийн үйлчилгээ	4,804.70	1,416.35	3.39	29.48
81834 Боловсролын стандарт, сургалты	253,961.70	247,288.95	6.67	97.37
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	43,749.60	40,836.52	2.91	93.34

71802 Ерөнхий боловсрол	1,523,421.80	1,393,082.62	130.34	91.44
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү	9,613.10	7,306.83	2.31	76.01
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	213,184.60	204,183.92	9.00	95.78
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,762.50	1,720.00	1.04	62.26
81801 үдийн цай хөтөлбөр	45,529.60	19,878.30	25.65	43.66
81806 Дотуур байрны үйлчилгээ	185,804.40	135,694.74	50.11	73.03
81834 Боловсролын стандарт, сургалты	844,739.00	827,706.49	17.03	97.98
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	221,788.60	196,592.33	25.20	88.64
71806 Насан туршын болон албан бус боловсрол	10,012.20	2,778.89	7.23	27.76
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	10,012.20	2,778.89	7.23	27.76
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	102,943.20	556.40	102.39	0.54
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	102,943.20	556.40	102.39	0.54

Эх сурвалж: Баянлиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4 байгууллага 99987.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2 байгууллага 32496.7 мянга, нийт 132484.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт 17. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТ	ИТХ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	Нийт
Нийт нэмэлт санхүүжилтийн орлого	32,553.2	-	63,232.1	12,360.6	24,338.2	132,484.1
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-	-	-	-	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,110.2	-	56,178.4	12,360.6	24,338.2	99,987.4
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,443.0	-	7,053.7	-	-	32,496.7
НИЙТ ЗАРЛАГА	30,558.2		63,230.4	12,360.6	24,338.2	130,487.4
Бараа, ажил үйлчилгээний зардал	25,819.1		7,052.0	-	4,939.9	37,811.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,739.1	-	26,660.2			31,399.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	29,518.20	12,360.6	19,398.3	61,277.1
ТӨВЛӨРҮҮЛСЭН	1,995.0		1.7	-	-	1,996.7

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	12	-	
2	Хагас жил	3	3	3	-	
3	Улирал бүр	2	8	8	-	
4	Сар бүр	5	60	60	-	
5	Тухай бүр	6	72	72	-	
	Нийт	28	155	155	-	

Эх сурвалж. Баянлиг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 155 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 4 санхүүгийн тайланд түүвэрт хамруулан иргэдийн төлөөлөгчдийн санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт, 1 байгууллага буюу Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн байна.

"ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"

**БАЯНЛИГ
СУМЫН
ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛЬ**

Тооллогын бүртгэл ирүүлээгүй, бараа материалын тодруулгад 1153,4 мянган төгрөгийн эм боох материалын орлого зарлага байгаа боловч эд хариуцагчийн тайлан байхгүй. Бараа үйлчилгээний бусад зардлаас 19550,0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, хөрөнгөөс "Санко маркетинг Монголиа" ХХК-ийн нийлүүлсэн 9950,0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж нь ирээгүй байхад хөрөнгөд орлогоор бүртгэсэн, "ЭБЦТС" ТӨХК-д 226,8 мянган төгрөгийн өглөгтэй байхад тайланд тусгаагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 13.4т заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх", "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 132061.0 мянган төгрөгийн 21 алдаа, зөрчил илэрснээс 22023.0 мянган төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 63233.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 40167.0 мянган төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 заалт бүхий зөвлөмж өгч, 6639.0 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулжээ.

Баянлиг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдааг санхүүгийн тайланд залруулж, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж ажиллах 1 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- 2019 оны аудит хийсэн үр дүнгийн тайлангийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн программд зөрүүтэй оруулсан байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль эд хогшил урсгал засварын зардал болох 494.0 мянга, Цэцэрлэг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болох 1389.7 мянга, ЗДТГ нь бараа үйлчилгээний бусад зардал 1123.3 мянга, Эрүүл мэндийн төв нь урсгал шилжүүлэг болох 117.2 мянга, соёлын төв нь бараа үйлчилгээний бусад зардал 30925.6 мянган төгрөгийн зөрүүтэй тусгасан. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд ОНХС-ийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 156853.5 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардал руу бичсэнийг е тайланд залруулсан.

- 2019 оны аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлангийн 2019 оны жилийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн программд зөрүүтэй оруулсан байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль эд хогшил урсгал засварын зардлыг 54932.0 мянга, бага сургууль эд хогшил урсгал засварын зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардлын 16370.0 мянга, цэцэрлэг Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг болох 4267.2 мянга, сумын ИТХ үндсэн цалин, хангамж бараа материалын зардал, тээвэр шатахууныг зардал, нийт 16388.2 мянга, Эрүүл мэндийн төв нь нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал болох нийт 11688.9 мянга, Соёлын төв эд хогшил, урсгал засварын зардал болох 2500.0 мянган төгрөгийн зардлуудыг зөрүүтэй тусгасан.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар аудитлагдсан тайлангийн 2020 оны эцсийн үлдэгдлийг Э-тайлангийн 2021 оны эхний үлдэгдлээр зөв оруулсан эсэхийг нягталж тодруулах шаардлагатай мөн нягтлан бодогч нарын хариуцлагыг дээшлүүлэн санхүүгийн программын эцсийн үлдэгдлийг э-тайлангийн үлдэгдлээр зөв хаалт хийсэн эсэх дээр

Баянлиг сумын Санхүүгийн албаны дарга хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.1.1. Илрүүлэлт: Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиглаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2. Эрсдэл: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих санхүүгийн албаны даргын дотоод хяналтыг сайжруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.1.1. Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 12 зээлдэгч 60957.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7 “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна..

4.1.2. Эрсдэл: Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох, авлага найдваргүй болох, орлогын төлөвлөгөө тасрах.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 12 зээлдэгчийн 60957.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч, заасан хугацаанд төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн: АУДИТОР		Б.НАРАНГЭРЭЛ 2021.03.25
Анхан шатанд хянасан: АУДИТЫН МЕНЕЖЕР		А.ЦЭЭНЯМ 2021.03.25
Хоёр дахь шатанд хянасан: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.МӨНХБАТ 2021.03.25

Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Баянлиг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/14/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянлиг сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	2019 оны аудит хийсэн үр дүнгийн тайлангийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн программд зөрүүтэй оруулсан байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль эд хогшил урсгал засварын зардал болох 494.0 мянга, Цэцэрлэг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болох 1389.7 мянга, ЗДТГ нь бараа үйлчилгээний бусад зардал 1123.3 мянга, Эрүүл мэндийн төв нь урсгал шилжүүлэг болох 117.2 мянга, Соёлын төв нь бараа үйлчилгээний бусад зардал 30925.6 мянган төгрөгийн зөрүүтэй тусгасан. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд ОНХС-ийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 156853.5 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардал руу бичсэнийг ө тайланд залруулсан.	187810.1	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
2	2019 оны аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлангийн 2019 оны жилийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн программд зөрүүтэй оруулсан байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль эд хогшил урсгал засварын зардлыг 54932.0 мянга, бага сургууль эд хогшил урсгал засварын зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардлын 16370.0 мянга, цэцэрлэг Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг болох 4267.2 мянга, сумын ИТХ үндсэн цалин, хангамж бараа материалын зардал, тээвэр шатахууныг зардал, нийт 16388.2 мянга, Эрүүл мэндийн төв нь нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал болох нийт 11688.9 мянга, Соёлын төв эд хогшил, урсгал засварын зардал болох 2500.0 мянган төгрөгийн зардлуудыг зөрүүтэй тусгасан.	0	Санхүүгийн тайланд залруулсан.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
3	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
4	Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 12 зээлдэгч 60957.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.	60957.1	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	О.Мөнхбат, Ш.Хоролсүрэн
1	Өвөрхангай аймаг дахь ЭБЦТС - ТӨХК-д 2-р сард нэхэмжлэхгүйгээр 463.2 мянган төгрөгийг шилжүүлсэн / Э-баримт шивэгдээгүй/, мөн 2 дугаар сарын гэрлийн мөнгийг 27.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлээд авлагаар тусгаагүй, МЦХ компанид 1 сарын төлбөр 108.9 мянган төгрөгийг илүү төлөөд авлагаар бүртгээгүй.	599.3	Төлбөрийн акт тогтоосон	Эрхлэгч нягтлан бодогч	Н.Хүрлээ, Ц.Төмөрчөдөр
2	ХХОАТ-ын тооцоог татварын тайлангай тулган баталгаажуулахад өмнөх оны балансад тусгаагүй 853.8 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна.	853.8	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч нягтлан бодогч	Н.Хүрлээ, Ц.Төмөрчөдөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
3	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 560,0 мянган төгрөгийн үнэтэй хивс, БСУГ-аас өгсөн тус бүр нь 400.0 мянган төгрөгийн үнэтэй 2ш телевизоргыг ҮХ-д бүртгээгүй бараа материалд орлого авсан.	1360.0	Санхүүгийн тайланд залруулсан	Эрхлэгч нягтлан бодогч	Н.Хүрлээ, Ц.Төмөрчедөр
4	Цалин, НДШ-ийн зардлыг давтан тооцоолох явцад үр дүнгийн тайлангийн цалингийн зардал 4884.6 мянган төгрөгөөр илүү, АО-ийн төлөх НДШ-ийн зардал 4901.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.	4901.2	Санхүүгийн тайланд залруулсан	Эрхлэгч нягтлан бодогч	Н.Хүрлээ, Ц.Төмөрчедөр
5	Шилэн дансны сайтад нийт 151 мэдээлэл байршуулахаас давхардсан тоогоор 6 төрлийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	0	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч нягтлан бодогч	Н.Хүрлээ, Ц.Төмөрчедөр
6	Хөрөнгийн дахин үнэлгээ данс санхүүгийн тайланд 221745.0 мянган төгрөг, ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 250397.4 мянган төгрөг, ОНӨГ-ын нэгтгэлд -223143.1 мянган төгрөг буюу 28651.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан.	0	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч нягтлан бодогч	Н.Хүрлээ, Ц.Төмөрчедөр
7	Тухайн байгууллага нь НБББББ байхгүй байна	0	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч нягтлан бодогч	Н.Хүрлээ, Ц.Төмөрчедөр
8	НББ-ийн дансны үлдэгдэл, гүйлгээний санхүүгийн тайлан, тодруулга дахь дүнг МХЖ, ЕД, Хөрөнгө материалын орлого, зарлагын дэлгэрэнгүй бүртгэл, нярвын тайлантай тулган шалгахад ААМ-ын эхний үлдэгдэл 2625.2 төгрөгөөр, орлого 3325.0 мянган төгрөгөөр, зарлага 699.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлан гаргасан.	3325.0	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч нягтлан бодогч	Н.Хүрлээ, Ц.Төмөрчедөр
9	Цалингийн зардлыг давтан тооцоолоход 207,0 мянган төгрөгийн цалин илүү олгосон атлаа авлагаар тусгаагүй, ЭМНДШ-д 224,0 мянган төгрөгийн дутуу шилжүүлсэн байхад өглөгөөр тусгаагүй	431.0	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	С.Цэдэндорж, Ц.Төмөрчедөр
10	Мөнгөн хөрөнгийн журналыг харилцахын анхан шатны баримттай тулган шалгахад "ЭБЦТС" ТӨХК-д 226,8 мянган төгрөгийн өглөгтэй байхад өглөг тусгаагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.	226.8	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	С.Цэдэндорж, Ц.Төмөрчедөр
11	"Санко маркетинг Монголиа" ХХК-ийн нийлүүлсэн 9950,0 мянган төгрөг он гаргаж ирсэн байхад өмнөх оны санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.	19550.0	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	С.Цэдэндорж, Ц.Төмөрчедөр
12	Шилэн дансны сайтад 151 мэдээ мэдээлэхээс 3 мэдээллийг байршуулаагүй байна.	0	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	С.Цэдэндорж, Ц.Төмөрчедөр
13	Тухайн байгууллага нь эд хөрөнгийн тооллогын бүртгэл ирүүлээгүй. Бараа материалын тодруулгад 1153,4 мянган төгрөгийн эм боох материалын орлого зарлага байгаа боловч эд хариуцагчийн тайлан байхгүй.	1153.4	Зөвлөмж өгсөн	Захирал, нягтлан бодогч	С.Цэдэндорж, Ц.Төмөрчедөр
14	Тээврийн хэрэгслийн татварыг давхардуулан шилжүүлсний улмаас 148.5 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.	148.5	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх, Г.Тунгалаг
15	Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн ирүүлсэн өвс тэжээлийн тооцоогоор 2020 онд нийт 66300.4 мянган төгрөгийн өвс тэжээл нийлүүлж 50604.4 мянган төгрөгийн авлагатай гарсан байхад тооцоо нийлээгүй, данс бүртгэлд тусгаагүй байна.	50604.4	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх, Г.Тунгалаг
16	Тоног төхөөрөмжид бүртгэлтэй 12628.3 мянган төгрөгийн дизель моторыг 2011 оны 4-р сарын 14-ны өдөр аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу Баянхонгор аймгийн Эрчим Хүч ЦТХХК-нд акт үйлдэн хүлээлгэн өгсөн боловч өнөөг хүртэл тус моторыг данснаас хасаагүй байна.	12628.3	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх, Г.Тунгалаг
17	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнээс 21522.0 мянган төгрөгийн гүйлгээ 11 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх, Г.Тунгалаг
18	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд санхүүгийн тайлангаар 85749.9 мянган төгрөг байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн дахин үнэлгээний нөөц хэсэгт 69838.6 мянган төгрөг буюу 15911.3 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	15911.3	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх, Г.Тунгалаг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
19	Баянлиг сумын Засаг дарга, "Чандмань Их Баян Уул" Хоршооны 2020.02.05-ны өдөр "Баянлиг сумын өвсний нөөц бүрдүүлэх" 02 тоот гэрээ байгуулан өвсний үнэ 9990.0 мянган төгрөг шилжүүлсэн байхад 2020.12.31-ны өдрийн байдлаар өвсийг нийлүүлээгүй байна	9990.0	Төлбөрийн акт	Засаг дарга нягтлан бодогч	О.Мөнхбат, Мөнхцэцэг
20	Баянлиг сумын Засаг дарга, "Хар ботго" хоршоотой 2020.02.05-ны өдөр "Баянлиг сумын гэр хороололд гэрэлтүүлэг хийх" 03 тоот гэрээ байгуулан, 10000.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч 2020.12.31-ны өдрийн байдлаар тус гэрэлтүүлгийн ажил хийгдээгүй байна	10000.0	Төлбөрийн акт	Засаг дарга нягтлан бодогч	О.Мөнхбат, Мөнхцэцэг
21	Ажил олгогчоос төлөх НДШ-ийн 330.3 мянган төгрөгийг даттуулагчийн НДШ-ийн зардлаар тайлагнасан, НДШ-ийн илүү төлөлтийн 47.9 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй	378.2	Санхүүгийн тайланд залруулсан	Дарга, нягтлан бодогч	Д.Нансалмаа, Р.Хандмаа

оОо